



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 129

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 31 дүгээр цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Дээд шатны төсвийн захирагчаас тус цэцэрлэгийн тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн тайлант онд нийт 3 удаа өөрчилж, зохицуулалт хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулан өөрчилж байгаа нь төсвийн төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалин хөлсийг шинэчлэн тогтоосноор цалингийн зардал өнгөрсөн оны гүйцэтгэлээс 64.8 хувиар өссөн байна.

4525026214

Бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дархан-Уул аймгийн Дархан сумын 31 дүгээр цэцэрлэг нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 43 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 96.0 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР





САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан Уул аймгийн Дархан сумын 31 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/96/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Дархан-Уул аймаг
2025 он

Газрын дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр
Утас:70373089, 99023682
Цахим хаяг:munkhbayarsh@audit.gov.mn
Аудитын менежер: У.Батсүрэн
Утас:99023682
Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn
Ахлах аудитор: С.Батцэцэг
Утас:99377479
Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Пийк-Ом Аудит ХХК
Захирал: Б.Жаргалсайхан
Утас:99862066
Цахим хаяг:peakomaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчинд, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	15
5.1 Төлбөрийн акт	16
5.2 Албан шаардлага	16
5.3 Зөвлөмж	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	109,088,379.87	167,543,560.87
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	76,154,646.87	123,832,393.87
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	76,154,646.87	123,832,393.87
31210	Төгрөг	76,154,646.87	123,832,393.87
31211	Төрийн сангийн харилцах	76,154,646.87	123,832,393.87
33	АВЛАГА	0.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	32,933,733.00	43,711,167.00
35100	Түүхий эд материал	692,980.00	599,290.00
35130	Эм боох материал	692,980.00	599,290.00
35400	Хангамжийн материал	32,240,753.00	43,111,877.00
35410	Бичиг хэргийн материал	491,000.00	466,000.00
35420	Аж ахуйн материал	25,890,540.00	31,582,440.00
35450	Барилгын засварын материал	2,960,500.00	2,828,500.00
35460	Хүнсний материал	2,870,363.00	8,234,937.00
35470	Бусад хангамжийн материал	28,350.00	0.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,121,116,164.51	1,094,056,741.04
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,121,116,164.51	1,094,056,741.04
39200	Биет хөрөнгө	1,060,863,664.51	1,034,216,741.04
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,017,528,936.96	1,017,528,936.96
39202	Хуримтлагдсан элэгдэл	(76,887,874.80)	(115,331,812.20)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	38,187,845.00	64,450,845.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(11,967,957.40)	(17,245,901.19)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	43,457,956.00	44,247,956.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,934,817.13)	(16,551,912.89)
39214	Бусад үндсэн хөрөнгө	69,425,038.92	69,425,038.92
39215	Хуримтлагдсан элэгдэл	(8,399,463.04)	(12,760,409.56)
39217	Ном	454,000.00	454,000.00
39300	Биет бус хөрөнгө	60,252,500.00	59,840,000.00
39301	Програм хангамж	1,350,000.00	1,350,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(937,500.00)	(1,350,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	59,840,000.00	59,840,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,230,204,544.38	1,261,600,301.91
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,230,204,544.38	1,261,600,301.91
51	Засгийн газрын хувь оролцоо	1,230,204,544.38	1,261,600,301.91
51100	Засгийн газрын оруулсан капитал	59,840,000.00	59,840,000.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	59,840,000.00	59,840,000.00
51200	Хуримтлагдсан үр дүн	1,170,364,544.38	1,201,760,301.91
51210	Өмнөх үеийн үр дүн	1,187,858,861.69	1,170,364,544.38
51220	Тайлант үеийн үр дүн	(17,494,317.31)	31,395,757.53
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,230,204,544.38	1,261,600,301.91



2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	430,717,916.06	740,355,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	815,000.00	23,283,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	815,000.00	23,283,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	35,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,000.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	780,000.00	23,283,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	429,902,916.06	717,072,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	414,191,700.00	690,472,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	414,191,700.00	690,472,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	15,711,216.06	26,600,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	15,711,216.06	26,600,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	448,212,233.37	706,258,284.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	448,212,233.37	706,258,284.26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	448,212,233.37	691,524,461.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	282,953,612.76	466,586,662.00
210101	Үндсэн цалин	199,457,640.89	334,575,045.00
210102	Нэмэгдэл	73,940,809.87	110,571,745.00
210104	Урамшуулал	9,555,162.00	21,439,872.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,716,593.85	60,586,570.00
210201	Тэтгэврийн даатгал	25,218,725.00	41,483,784.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,923,891.30	4,878,405.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,286,350.96	2,430,679.00
210204	Ажилгүйдлийн даатгал	571,836.23	2,379,890.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,715,790.36	9,413,812.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,411,216.06	20,066,477.00
210301	Гэрэл, цахилгаан	3,880,706.12	5,599,819.56
210302	Түлш, халаалт	6,093,985.74	6,198,810.64
210303	Цэвэр, бохир ус	4,436,524.20	8,267,846.80
2104	Хангамж, бараа материалын зардал	3,079,000.00	567,100.00
210401	Бичиг хэрэг	3,079,000.00	-
210408	Бараа материал акталсны зардал	-	567,100.00
2105	Нормативт зардал	48,576,475.50	65,035,771.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	161,530.00	-
210502	Хоол, хүнс	48,414,945.50	65,035,771.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,300,000.00	5,246,000.00
210604	Урсгал засвар	1,300,000.00	5,246,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	841,200.00	2,240,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	841,200.00	2,240,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	60,334,135.20	71,195,281.26
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,828,040.00	9,322,216.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	6,556,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	54,506,095.20	55,316,465.26
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	14,733,823.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	14,700,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	14,700,300.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	33,523.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	33,523.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(17,494,317.31)	34,096,715.74
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	2,700,958.21



225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	-	2,700,958.21
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(17,494,317.31)	31,395,757.53


2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	430,079,700.00	717,072,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	35,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	35,000.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	35,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	430,044,700.00	717,072,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	414,191,700.00	690,472,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	414,191,700.00	690,472,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	15,853,000.00	26,600,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	15,853,000.00	26,600,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	399,581,827.67	661,719,253.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	399,581,827.67	661,719,253.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	399,581,827.67	646,985,430.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	282,953,612.76	466,586,662.00
210101	Үндсэн цалин	199,457,640.89	334,575,045.00
210102	Нэмэгдэл	73,940,809.87	110,571,745.00
210104	Урамшуулал	9,555,162.00	21,439,872.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,716,593.85	60,586,570.00
210201	Тэтгэврийн даатгал	25,218,725.00	41,483,784.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,923,891.30	4,878,405.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,286,350.96	2,430,679.00
210204	Ажилгүйдлийн даатгал	571,836.23	2,379,890.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,715,790.36	9,413,812.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,411,216.06	20,066,477.00
210301	Гэрэл, цахилгаан	3,880,706.12	5,599,819.56
210302	Түлш, халаалт	6,093,985.74	6,198,810.64
210303	Цэвэр, бохир ус	4,436,524.20	8,267,846.80
2104	Хангамж, бараа материалын зардал	35,000.00	-
210401	Бичиг хэрэг	35,000.00	-
2105	Нормативт зардал	50,889,565.00	70,400,345.00
210502	Хоол, хүнс	50,889,565.00	70,400,345.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,300,000.00	6,500,000.00
210604	Урсгал засвар	1,300,000.00	6,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	841,200.00	2,240,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	841,200.00	2,240,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,434,640.00	20,604,776.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,911,040.00	14,048,176.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,523,600.00	6,556,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	141,783.94	14,733,823.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	14,700,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	14,700,300.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	141,783.94	33,523.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	141,783.94	33,523.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	30,356,088.39	55,352,747.00



V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	27,000.00	7,675,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	27,000.00	7,675,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	27,000.00	7,675,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	27,000.00	7,675,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(27,000.00)	(7,675,000.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	30,329,088.39	47,677,747.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	45,825,558.48	76,154,646.87
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	76,154,646.87	123,832,393.87



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	59,840,000.00	-	1,187,858,861.69	1,247,698,861.69
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	59,840,000.00	-	1,187,858,861.69	1,247,698,861.69
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(17,494,317.31)	(17,494,317.31)
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	59,840,000.00	-	1,170,364,544.38	1,230,204,544.38
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	59,840,000.00	-	1,170,364,544.38	1,230,204,544.38
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	59,840,000.00	-	1,170,364,544.38	1,230,204,544.38
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
17	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	31,395,757.53	31,395,757.53
20	2024 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	59,840,000.00	-	1,201,760,301.91	1,261,600,301.91



2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	803,089,100.00	669,360,730.00	133,728,370.00	83.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	803,089,100.00	669,360,730.00	133,728,370.00	83.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	788,388,800.00	654,660,430.00	133,728,370.00	83.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	577,615,700.00	466,586,662.00	111,029,038.00	80.78
210101	Үндсэн цалин	422,229,000.00	334,575,045.00	87,653,955.00	79.24
210102	Нэмэгдэл	146,075,000.00	110,571,745.00	35,503,255.00	75.70
210104	Урамшуулал	9,311,700.00	21,439,872.00	(12,128,172.00)	230.25
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,527,000.00	60,586,570.00	5,940,430.00	91.07
210201	Тэтгэврийн даатгал	45,239,900.00	41,483,784.00	3,756,116.00	91.70
210202	Тэтгэмжийн даатгал	5,320,700.00	4,878,405.00	442,295.00	91.69
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,661,000.00	2,430,679.00	230,321.00	91.34
210204	Ажилгүйдлийн даатгал	2,661,000.00	2,379,890.00	281,110.00	89.44
210205	Эрүүл мэндийн даатгал	10,644,400.00	9,413,812.00	1,230,588.00	88.44
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,962,500.00	20,066,477.00	9,896,023.00	66.97
210301	Гэрэл, цахилгаан	12,004,900.00	5,599,819.56	6,405,080.44	46.65
210302	Түлш, халаалт	7,778,700.00	6,198,810.64	1,579,889.36	79.69
210303	Цэвэр, бохир ус	10,178,900.00	8,267,846.80	1,911,053.20	81.23
2105	Нормативт зардал	74,367,100.00	70,400,345.00	3,966,755.00	94.67
210502	Хоол, хүнс	74,367,100.00	70,400,345.00	3,966,755.00	94.67
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,500,000.00	6,500,000.00		100.00
210604	Урсгал засвар	6,500,000.00	6,500,000.00		100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,241,000.00	2,240,600.00	400.00	99.98
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,241,000.00	2,240,600.00	400.00	99.98
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,175,500.00	28,279,776.00	2,895,724.00	90.71
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,618,900.00	21,723,176.00	2,895,724.00	88.24
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,556,600.00	6,556,600.00		100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,700,300.00	14,700,300.00		100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,700,300.00	14,700,300.00		100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14,700,300.00	14,700,300.00		100.00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	803,089,100.00	717,038,477.00	86,050,623.00	89.29
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	766,626,600.00	690,472,000.00	76,154,600.00	90.07
131001	Улсын төсвөөс санхүүжих	766,626,600.00	690,472,000.00	76,154,600.00	90.07
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	36,462,500.00	26,566,477.00	9,896,023.00	72.86
132001	Орон нутгийн төсвөөс	36,462,500.00	26,566,477.00	9,896,023.00	72.86
124	БУСАД ЭХ ҮҮСВЭР	0.00	0.00	0.00	0.00
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	76,154,646.87	(76,154,646.87)	0.00

31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	123,832,393.87	(123,832,393.87)	0.00
1	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	0.00			0.00
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00		1.00	0.00
3	Төсвийн байгууллага	2.00	2.00		100.00
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25.00	25.00		100.00
6	Удирдах ажилтан	4.00	3.00	1.00	75.00
7	Гүйцэтгэх ажилтан	30.00	29.00	1.00	96.67
8	Үйлчлэх ажилтан	14.00	14.00		100.00
15	Төрийн өмчит СӨБ байгууллага	171.00	171.00		100.00
24	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	25.00	25.00		100.00
28	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	13.00	13.00		100.00
32	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	1.00	1.00		100.00
33	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	11.00	11.00		100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан байхгүй байна.

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Дархан сумын 31 дүгээр цэцэрлэг нь "Хүүхдийн нийгэм сэтгэл зүй, танин мэдэхүйн хөгжлийг дэмжих, боловсрол эзэмшихэд тулгарч буй бэрхшээлийг арилгаж, сурах тэгш боломж бүрдүүлэх, хувь хүүхдийн онцлогт нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанар, үр дүнтэй зохион байгуулах, хамтран суралцах арга барилыг сургалтад нэвтрүүлэн ажиллана" гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- Батлагдсан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хүүхэд бүрийн нийгэм, сэтгэл зүй, эрүүл мэнд, танин мэдэхүйн хөгжилд дэмжлэг үзүүлэх тэдний ялгаатай байдал, сурах хэв маягийг харгалзан амжилттай суралцах тэгш боломж бүрдүүлэхэд сургалт үйл ажиллагааг чиглүүлж, агуулгын хоцрогдлыг арилгах, үр дүнд хүрэх тэгш боломжийг бий болгох
- Сургуулийн өмнөх насны хүүхдийг бие даан суралцах чадварыг дэмжих олон хувилбарт арга, хэлбэрүүдийг туршин хэрэгжүүлж биеэ даасан, хариуцлагатай өмнөө тулгарч буй бэрхшээлийг даван туулах, өөртөө итгэлтэй байх чадваруудыг эзэмшүүлэхэд багш сургалтын арга зүй технологи, үнэлгээгээр дэмжих
- Багшийн хөгжлийг дэмжих уян хатан, олон хэлбэрт сургалт үйл ажиллагааг хэрэгжүүлж багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах
- Хүүхдийн хүртэн таньж мэдрэх болон бүтээлч үйлийг дэмжсэн монтессори сургалтын арга зүйг сургалтыг сайжруулах
- Хүүхдийн нийгэмшихүйн чадвар далыг өдөр тутмын хөгжүүлэх үйл ажиллагаа болон сонголтын буланд баг жижиг бүлгээр тоглох явцад нь дэмжин төлөвшүүлэх
Дархан-Уул аймгийн Дархан сумын сумын өргөө багийн харьяа 2-5 насны хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагааг зохион байгуулах.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчинд, дотоод орчин

Тус цэцэрлэг нь Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад эрхийн актыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой;
- Засгийн газрын 2024 оны 01 сарын 25-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор "Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам" ;
- Засгийн газрын 2024 оны 01 сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор "Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам";
- Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон;
- Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн 82 дугаар тогтоолоор хөдөө орон нутгийн нэмэгдэл шинэчлэгдсэн,

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн зүгээс дотоод аудитын хяналт, шалгалт хийгдээгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 31 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус цэцэрлэгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Санхүүгийн үйл ажиллагаанд 2020 онд баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж өөрийн байгууллагын онцлог нөхцөлд тулгуурлан хууль эрх зүйн орчин болон, үйл ажиллагааныхаа хүрээнд нэмэлт өөрчлөлтүүдийг тушаал гарган хавсаргасан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан-Уул аймгийн Дархан сумын 31 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн цалин хөлсний бодлогод МУ-ын ЗГ-ын тогтоолын дагуу өөрчлөлт орсон.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 31,395.8 мянган төгрөгөөр буюу 2.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	76,154.6	123,832.4	47,677.7
Авлага	-	-	-
Бараа материал	32,933.7	43,711.2	10,777.5
Үндсэн хөрөнгө	1,121,116.2	1,094,056.7	(27,059.4)
Нийт хөрөнгө	1,230,204.5	1,261,600.3	31,395.8
Богино хугацаат өр төлбөр	-	-	-
Эздийн өмчийн дүн	1,230,204.5	1,261,600.3	31,395.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,230,204.5	1,261,600.3	31,395.8

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 123,832.4 мянган төгрөг болж өмнөх оноос 47,677.7 мянган төгрөгөөр өссөн нь тухайн байгууллагын төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал"-ын 8.7-д "Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ" гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнасан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 43,711.2 мянган төгрөг болж 10,777.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 90,685.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 79,908.3 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө 27,059.4 мянган төгрөгөөр буурахад хуримтлагдсан элэгдлийн өсөлт голлон нөлөөлжээ. Тодруулбал тайлант онд төсвийн хөрөнгөөр 7,675.0 мянган төгрөгийн сургалтын тоног төхөөрөмж, Дархан-Уул аймгийн Боловсролын газраас 24,901.5 мянган төгрөгийн зөөврийн компьютер, аймгийн Засаг даргын 2024 оны 12 сарын 04 өдрийн 01-А/491 тоот захирамжаар орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 8,340.0 мянган төгрөгийн угаалгын тоног төхөөрөмж, 3,450.0 мянган төгрөгийн хоолны халуун тогоог үнэ төлбөргүй хүлээн авсан, 3,905.0 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй хөрөнгийг 12 дугаар цэцэрлэгт шилжүүлсэн, тайлант онд 55,316.5 мянган төгрөгийн элэгдэл тооцож, зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,261,600.3 мянган төгрөг болж 31,395.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 462,294.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 50,915.2 мянган төгрөг, нийт зарлагыг 513,209.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг улсын төсвийн санхүүжилтийг 38,859.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 501,153.8 мянган төгрөг, орон нутгийн төсвийг 14,452.7 мянган төгрөгөөр бууруулж 36,462.5 мянган төгрөг, нийт 537,616.3 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд төсвийн хуваарьт 3 удаа өөрчлөлт орж, улсын төсвийг 190,515.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон бол орон нутгийн төсөвт тодотгол хийгээгүй байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 766,626.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 36,462.5 мянган төгрөг, нийт 803,089.1 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр улсын төсвөөс 690,472.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 26,600.0 мянган төгрөг, нийт 717,072.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, зарлагын гүйцэтгэл 669,324.7 мянган төгрөг буюу 83.4 хувьтай зарцуулж, орон нутгийн төсвөөс зарцуулаагүй үлдсэн 33.5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлснээр мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 47,677.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	71801	Сургуулийн өмнөх боловсрол	803,089.1	669,360.7	(133,728.4)	83.4
1	80111	Тогтмол зардал	36,462.5	26,600.0	(9,862.5)	73.0
2	80233	Хүүхэд хамгаалал	1,115.0	1,115.0	0.0	100.0

3	81605	Эрүүл мэндийг дэмжих зардал	2,337.8	2,308.0	(29.8)	98.7
4	81807	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	74,367.1	70,400.3	(3,966.8)	94.7
5	81816	Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр	2,700.2	2,690.0	(10.2)	99.6
6	81823	Багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	1,383.7	651.0	(732.7)	47.0
7	81834	Боловсролын стандарт	653,501.7	534,997.7	(118,504.0)	81.9
8	81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа хангах	31,221.1	30,632.2	(588.90)	98.1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд орлого, зарлагын гүйлгээ байхгүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл:

2024 оны худалдан авах ажиллагааг урсгал төсвийн хүрээнд хуулийн дагуу хугацаанд нь tender.gov.mn, shilendans.gov.mn сайтуудаар байршуулан нийтэлж, тайланг цахим болон цаасаар хүргүүлж ажилласан байна. tender.gov.mn сайтад хүүхдийн хоол хүнсний нээлттэй тендер шалгаруулалтыг тайлагнаж ажилласан байна. Хүүхдийн хоол хүнс худалдан авах нээлттэй тендер шалгаруулалтыг тайлант онд 4 удаа зарласан боловч тендер харилцагч орж ирээгүй учир ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 30.4.3-т заасны дагуу гэрээт байгууллагуудтай хамтран ажиллах, шууд худалдан авах гэрээг хийж ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 31 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс 2024 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн хооронд Пийк Ом Аудит ХХК-ын аудитор А.Батболд гүйцэтгэж, захирал Б.Жаргалсайхан хянан удирдаж, чанарын хяналтыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 31 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Пийк-Ом Аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 3 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлан дахь нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлан дахь нийт зардал 448,354.0 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 8,967.0 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тайлант хугацаанд төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд алдаа, зөрчил илрээгүй болно.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 1,939,9 мянган төгрөгийн зөрчил илрүүлж 2 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	1,939,9	2	1,939,9	100
Нийт дүн	2	1,939,9	2	1,939,9	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 13.063.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 7,675.0 мянган төгрөгийн 1 алдааг аудитын явцад залруулж, 5,388.1 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, цаашид давтан гаргахгүй байх 1 зөрчилд зөвлөмж өглөө.

Мөнгөн гүйлгээний тайланд 7,675.0 мянган төгрөгөөр худалдан авсан хөрөнгийг бараа үйлчилгээний зардалын ангилалд тайлагнасан нь УСНББОУС 1 "Санхүүгийн тайлангийн толилуулга", УСНББОУС 17 "Үндсэн хөрөнгө", Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам", "Ангилал", "Толилуулга", "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байгаа тул санхүүгийн тайланг залруулав.

5.1 Төлбөрийн акт

Тайлант онд төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал илрээгүй болно.

5.2 Албан шаардлага

Цэцэрлэгийн эрхлэгч санхүүгийн ажилтнуудад улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан 5,388.1 мянган төгрөгийн балансын урамшуулал олгож, төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна гэж" заасантай тус тус нийцээгүй тул зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв..

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Тус цэцэрлэг нь хууль тогтоомжийн хүрээнд ахмадын сан байгуулаагүй нь Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь "Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган, цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах", Ахмадын сан байгуулан ажиллуулах журмын 1.3 дахь "Төсөвт байгууллагын тухайд цалингийн сангийн гурав хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, шаардагдах хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгана" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу ахмадын санг байгуулах, мөн алдааг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 -д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөв
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		
							Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо
Худалдан авсан хөрөнгийг бараа үйлчилгээний зардалын ангилалд тайлагнасан	1	7,675.0			1	7,675.0	1	7,675.0			

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчилийн нэгтгэл

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн н акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Балансын урамшуулалыг үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон.	1	5388,0			1	5388,0						
	1	5388,0			1	5388,0						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Төлбөрийн акт Тоо	Дүн	Албан шаардлага Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Ахмадын сан байгуулаагүй	1	0.00					1	0.00
Дүн	1	0.00					1	0.00
Нийт дүн	1	0.00					1	0.00